

АЗИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ТЭМЦЛИЙГ ЭРЧИМЖҮҮЛЬЕ

Ш. Сандаг, түүхийн ухааны доктор.

Бүгд Найрамдах Монгол Ард Улс ах дүү социалист орнууд, энхийг эрхэмлэгч бүх хүчний хамт даян дэлхий дээр намжмал, тсгтвортой байдлыг сахин хамгаалж бэхжүүлэхийн төлөө идэвхтэй тэмцдэг билээ.

БНМАУ энх тайванч гадаад бодлогынхоо энэ чиг шугамыг эгнэгт хэлбэрэлтгүй баримтлан Азийн социалист орны хувьд юуны өмнө тус тивийн улс түмний хооронд харилцан ойлголцох итгэлцэх явдлыг гүнзгийрүүлэхэд онцгой анхаарал тавьсаар ирсэн ба одоо ч тавьж байна.

Сүүлийн үед социалист орнууд дэлхий дахиныг хамарсан, мөн Европ, Ази болон бусад тивийн холбогдолтой чухал асуудлуудаар бүхэл бүтэн санал, санаачлагуудыг дэвшүүлсэн нь цөмийн дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах, улс түмний энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх ариун хэрэгт асар их хувь нэмэр боллоо.

1983 он эхлэхэд олон улсын байдал үргэлжлэн хурцадсаар л байна. Гэсэн хэдий боловч, дэвшилт хүн төрөлхтөн дэлхийн олон улсын улс төрийн бодлогонд дайн дажин өдөөгчдийн хэнээрхлийг ухаалаг хандлага эцсийн дүнд япах юм гэдэгт итгэлээ алдахгүй, өөдрөг сэтгэл дүүрэн байна.

Америкийн империализм тэргүүтэй харгислал, дайны хүчин гар хумхин суугаагүй, түүгээр ч үл барам, намжмал байдал, энх тайвны хэргийг бусниулах, дэлхийн соёл иргэншил хийгээд хүн төрөлхтнийг өөрсдийг нь устгахад хүргэж болзошгүй тийм цөмийн дайныг дэгдээхэд чиглэсэн ялт хэрэг явууллагаа улам өргөжүүлсээр байна. АНУ-ын засаг захиргаа бодит социализмын эсрэг өдөөх цөмийн дайнд «ялалт» байгуулж болох тухай, урьтан түрүүлж цохилт өгөх тухай, цөмийн «хязгаарлагдмал» юм уу «сунжирмал» дайн явуулж болох тухай гэхчилэн хэнээт «номлол» гаргаж дайны аюулыг ихэсгэж байна. Үүгээр үл барам Рейганы засаг захиргаа социализмын эсрэг «загалмайн аян дайн» зарлалаа.

Намжмал байдлын эсрэг амьсгал тогтоож дэлхий дахиныг байнгын айж эмээх нөхцөл, сэтгэл зүйн дайны байдалд барьж хүн төрөлхтнийг үхлийн аюулд түлхэн оруулах аливаа оролдлогын эсрэг социалист нөхөрлөлийн орнууд өөрийнхөө эрчимт гадаад бодлогоо сэргүүлэн тавьж улс түмний хөгжил дэвшил, аюулгүй байдлын эрх ашигт үйлчилдэг эдийн засаг, батлан хамгаалах хүчин чадлаа зузаатгаж байдаг билээ.

Бүх дэлхий дахины улс түмний санаа сэтгэлийг нэн их түгшүүлж буй асуудал бол цөмийн дайны өсөн нэмэгдэж байгаа аюул занал мөн. Энэ бол Европ, Ази, эсвэл өөр нэг тив ялгаагүй, хол ойрын улс орон гэхгүй нийтэд хамаатай ноцтой асуудал мөн бөгөөд түүнийг хамтын хүчээр нийт хүн төрөлхтний тусын тулд одоо даруйхан шийдвэрлэх явдал тулгараад байна.

Цөмийн дайн дэгдвэл «хязгаарлагдмал», «бүс нутгийн» хүрээнд явагдахгүй, харин ч агшин зуур хол ойрын улс орон, Европ, Америк, Ази,

Африк ялгалгүй нийт бүх тив, нийт газрын бөмбөрцгийг хамарч дэлхийн соёл иргэншлийг устгаж, хүн төрөлхтнийг өөрийг нь мөхөөхөд хүргэх учир, орон орны ард түмэн манай гаргийг нөмөрсөн энэ аюул заналын эсрэг бүх хүчээ нэгтгэн эрс шийдвэртэй тэмцэх явдал урьд урьдаас улам чухал болж байна.

Ийм ч учраас дайны эсрэг хөдөлгөөн дэлхий даяар урьд өмнө үзэгдээгүй өргөн далайцтай явагдаж байгаа нь санамсаргүй хэрэг бишээ.

ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю. В. Андропов сүүлийн үед дэвшүүлсэн саналууддаа, тухайлбал, ЗСБНХУ-ын 60-жилийн ойн баярын хуралдаан дээр хэлсэн үгэндээ хүн төрөлхтнийг цөмийн дайны ирмэгт түлхэж болзошгүй америкийн засаг захиргааны «тэглэх хувилбар» мэт мухар сохор өдөөн хатгалга, «МХ», далавчит пуужин үйлдвэрлэж, Европт дунд зайны 600 пуужин байрлуулж, ЗХУ-аас цэрэг зэвсгийн хүчээр давж гарах гэсэн үл бүтэх оролдлогыг няцааж, зэвсэглэл, юуны өмнө цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг тэнцвэртэй ба харилцан адил аюулгүй байх зарчмын үндсэн дээр эцэс болгож, зэвсэглэл хорогдуулах талаар тодорхой санал дэвшүүлжээ.

Нөхөр Ю. В. Андропов шинэ санал дэвшүүлэхдээ, тэнцвэртэй байдлыг хэвээр байлгах явдлыг хадгалж стратегийн зэвсэглэлийг 25-аас илүү хувиар хорогдуулах мөн аливаа дайн, түүний дотор санамсаргүй гарах дайнаас сэрэмжлэх, итгэлцэхэд хүрэхийн тулд зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоох, улсуудын хоорондын тайван, эвсэг нийцтэй харилцаа, намжмал байдалд буцаж орох, Еврол дахь байг устгах зориулалттай дунд зайны болон тактикийн, ер нь бүх төрлийн цөмийн зэвсгээс таггалзах, ЗСБНХУ ба НАТО-гийн орнууд дунд зайны тусгалтай зэвсэглэлээ гурав гаруй дахин хорогдуулах талаар хэлэлцэн тохиролцохыг уриалжээ.¹ Рэйганы «тэглэх» хувилбар гэгчийн явцгүй тухай өгүүлэхдээ, «энэ саналд Европ дахь НАТО-гийн пуужинт цөмийн зэвсгийн санг хэвээр байлгаж, тэр ч байтугай нэмэгдүүлэх нөхцөлд ЗСБНХУ-ын Европын төдийгүй, Азийн хэсэг дэх зөвлөлтийн дунд зайны пуужинг устгахыг зааж байгаа юм» гэжээ.

Цөмийн дайны аюулыг зайлуулах энэ бүх арга хэмжээ бол «бүх бүс нутагт чухал» ач холбогдолтой гэж нөхөр Ю. В. Андропов онцлон анхааруулжээ. Үүнтэй холбогдуулан Ю. В. Андропов цааш нь тэмдэглэхдээ, «Цөмийн ямар ч дайныг тухайлбал бага, том, хязгаарлагдмал, бүх нийтийг хамарсан ямар ч дайныг гаргаж болохгүй. Шинэ дайн өдөөгчдийг зогсохоос чухал зорилт одоо байхгүй. Бүх улс түмний амин чухал эрх ашиг үүнийг шаардаж байна. Ийм учраас Зөвлөлт Холбоот Улс түрүүлж цөмийн зэвсэг хэрэглэхгүй байх үүрэг дангаар авсныг дэлхий даяар сайшааж, найдлага тавин хүлээж авсан билээ. Цөмийн зэвсэгтэй бусад гүрэн манай жишээг дагах юм бол энэ нь цөмийн дайныг сэрэмжлэн зайлуулах үйлсэд үнэхээр жинтэй хувь нэмэр болох билээ»² гэжээ.

ЗСБНХУ-ын 60 жилийн ойд зориулсан баярын хуралдаанаас «Дэлхийн парламент, улс төрийн намууд болон ард түмэнд» хандан гаргасан уриалга, Ю. В. Андроповоос америкийн ерөнхийлөгч Рейганы АНУ-ын цэргийн бодлогын талаар хэлсэн үгний тухай «Правда» сонины сурвалжлагчийн асуултанд 1983 оны 3-р сарын 23-нд өгсөн хариу, мөн «Шпигельч (ХБНГУ) сэтгүүлд 1983 оны 4-р сарын 25-нд өгсөн хариу ЗХУ-ын Гадаад явдлын Яамны сайд А. А. Громыкогоос хэвлэлийн бага хурал дээр 1983 оны 4-р сарын 2-нд хэлсэн үг нь «зөвлөлтийн аюул» гэгчээр сүр далайлган АНУ, НАТО-г цэрэг зэвсгийн талаар ЗХУ ба со-

¹ Ю. В. Андропов. ЗСБНХУ-ын 60 жилийн ойг хуралдаан дээр тавьсан илтгэл. «Үнэн», 1982. 12. 23.

² Мөн тэнд.

циалист бусад орнуудаас давуутай болгоход чиглэсэн бүдүүлэг гүтгэлгийг няцааж, цөмийн дайны аюулыг зайлуулах тодорхой арга замыг зааж зөвлөлтийн тууштай энх тайванч гадаад бодлогыг дахин нотлон харууллаа.

Мөн энэ чигт Варшавын гэрээнд оролцогч улсуудын улс төрийн тунхаглал (1983 оны 1-р сарын 7) онцгой чухал алхам боллоо. Социалист орнуудын энх тайванч гадаад бодлогын бас нэг илрэл болсон энэхүү тунхаглал зэвсгийг, ялангуяа цөмийн зэвсгийг хорогдуулан, улмаар устгахын тулд шатчилсан программ боловсруулах, хүнийг үй олноор хөнөөх зэвсгийг хориглох конвенц боловсруулах, стратегийн зэвсгийг хязгаарлан хорогдуулах, Европт цөмийн зэвсгийг хязгаарлах тухай хэлэлцээ үр бүтээлтэй явуулах, гадаадын цэргийн баазыг татан буулгах, бусдын нутаг дэвсгэрээс гадаадын цэргийг гаргах талаар тодорхой санал гаргажээ. Зэвсэглэлийн хойноос хөөцөлдөхийг зогсоож зэвсэглэл хураах тухай нийтэд хамаарах нэн чухал энэ асуудлуудаас гадна, Ази ба бусад тивтэй холбоотой санал дэвшүүлжээ.³

Үүнд энэ талаар уул тунхаглалд заасан нь: «Орон нутгийн мөргөлдөөнүүд дэлхийн хэмжээний зэвсэгт мөргөлдөөн болж өргөжих аюул байгаа нь Ази, Африк, Латин Америкийн орнуудыг цэрэг-улс төрийн эвсэл холбоонд шууд буюу шууд бусаар татан оролцуулж, эвсэл бүлэглэлүүдийн үйл ажиллагааны хүрээг тэдгээрт дэлгэрүүлэх гэсэн оролдлогогой ихээхэн хэмжээгээр холбоотой юм. Зөвлөлгөөнд оролцогчид өөрийн холбооны үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэх бодол Варшавын гэрээнд оролцогч улсуудад байхгүйг нотлохын хамт эвслийнхээ үйл ажиллагааны бүсийг дэлхийн аль ч бүс нутаг, тухайлбал, Персийн буланд дэлгэрүүлэхээс татгалзахыг НАТО-гийн гишүүн улсуудад уриалж байна»⁴ гэжээ.

Мөн Варшавын гэрээнд оролцогч улсууд НАТО-д хандан харилцан «цэргийн хүч үл хэрэглэх, эв найрамдалт харилцаатай байх тухай гэрээ байгуулах санал»⁵ тавьжээ. Энэ нь МАХН-ын XVIII их хурлаас Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтлох, хүч үл хэрэглэх тухай конвенц боловсруулах талаар дэвшүүлсэн саналтай нэг чигтэй юм.

ЗХУКН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю. В. Андроповын удаа дараа дэвшүүлсэн санал, Варшавын гэрээний орнуудын тунхаглал нь Европ тивийн одоогийн байдалд дүн шинжилгээ хийж зэвсэглэлээр хөөцөлдөхийг зогсоож, зэвсэглэл хураах, цөмийн дайныг сэрэмжлэх зэрэг дэлхий дахиныг хамарсан нийтлэг асуудлуудаас гадна, Ази болон бусад тивтэй холбоотой тодорхой асуудлуудыг бас хөндсөн ажээ. Нөхөр Ю. В. Андроповын дэвшүүлсэн саналууд, Варшавын гэрээнд оролцогч улсуудын улс төрийн тунхаглалыг дэлхийн олон нийт, түүний дотор Монголын ард түмэн гүнээ талархан уггаж авч, баяр талархалаа дэвшүүлж байна.

МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал ЗХУ ба ах дүү бусад орны дээрх санаачлагыг дэмжин, америкийн засаг захиргааны дайнч санаархлыг няцаан хэлэхдээ «АНУ-ын засаг захиргаа цэргийн талаар давуутай болох зорилго өвөрлөж Зөвлөлт Холбоот Улс, АНУ-ын хооронд болон Варшавын гэрээ, НАТО-гийн хооронд тогтсон стратегийн

³ Варшавын гэрээнд оролцогч улсуудын улс төрийн тунхаглал. — «Үнэн» 1983—1—8.

⁴ Мөн тэнд.

⁵ Мөн тэнд.

тэнцвэртэй байдлыг алдагдуулах гэж улайран зүтгэж байна. Вашингтоныхон туйлын аюултай санаа өвөрлөж цөмийн дайнд практик дээр бэлтгэж байгаагаар дээрх чиг бодлогын аюул улам лавширч байна.

Европын болон ялангуяа манай Ази тивийн зарим том улсын эрх баригч бүлгийнхэн хонзогнох, милитарист бодол санаа өвөрлөн энэхүү мунхаг бодлогод татагдан орж байна. Империалист харгис хүчин, тэднийг аядан дагалдагчдын ийм чиг бодлого дайны сүйрлийн ирмэгт дэнжигнэх аюултай байдалд дэлхий дахиныг түлхэн оруулж байна.

Гэвч энх тайван, олон улсын намжмал байдлын төлөө, дайны аюулын эсрэг тэмцэж байгаа хүч хавьгүй илүү хүчирхэг юм. Эдгээр хүч давшилтаа хүчтэй болгож байна.

Варшавын гэрээнд оролцогч улсуудын Прагийн тунхаглал нь цөмийн дайныг сэрэмжлэн зайлуулах, олон улсын уур амьсгалыг үндсээр нь эрүүлжүүлэхийн төлөө тэмцэлд хүчирхэг түлхэц өглөө»⁶ гэжээ.

Прагийн тунхаглалын тухай БНМАУ-ын засгийн газрын 1983 оны 1-р сарын 17-ны мэдэгдэлд дурьдсан нь, «Варшавын Гэрээнд оролцогч улсуудын энх тайванч санаачлага нь Европ төдийгүй бусад бүх тивийн улс түмний энх амгалан аж төрөх амин чухал ашиг сонирхол, хүсэл эрмэлзлэлд нийцэж байна.

Улс гүрэн харилцан ойлголцож, итгэлцэх уур амьсгалыг бий болгох нь сайн хөршийн харилцааг хөгжүүлэх эн тэргүүний нөхцөл мөн гэж Бүгд Найрамдах Монгол Ард Улсад гүнээ итгэж байна.

Чухам үүнийг үндэслэн Ази, Номхон далайн улсуудын хооронд харилцан үл довтлох, хүч үл хэрэглэх тухай Конвенц байгуулах саналыг Бүгд Найрамдах Монгол Ард Улс дэвшүүлсэн билээ»⁷ гэжээ.

Ази тивийн энх тайван аюулгүй байдалд америкийн империализм ба тус тивийн харгис хүчнүүд заналхийлэх нь өдрөөс өдөрт улам нэмэгдэж байна.

Өргөн уудам Ази тивийн аль ч өнцөг буланг авч үзсэн эдгээр зээрхэг түрэмгий хүчний өдөөн хатгалгаанаас болж тогтвортой байдал алдагдаж, тус тивийн улс түмний харилцаа хурцадсаар байх ажээ.

Сүүлийн үед америкийн империализм дэлхийд энэ тохиолдолд Азид ноёрхлоо тогтоох санаархлаа шургуу хэрэгжүүлэхийн тулд Вашингтон-Токио-Сөулын гурвалжин цэрэг-стратегийн холбоо тогтоохыг элдвээр махран хөөцөлдөж байна.

Вашингтон болон Японы дотоодын хонзогногч хүчин Японыг милитаричлахыг шаардаж байна. 1983 онд Япон цэргийн төсөвт урьд урьдынхаас хамгийн их зардал 2,75 триллион иен буюу 11,5 миллиард доллар гаргахаар төлөвлөжээ. Энэ нь өмнөх жилийнхээс 6,5 хувиар давж байна. Америкийн засаг захиргаа Японы цэргийн ийм их зардлыг чамлаж, түүнийг жил бүр 10—12 хувиар өсгөхийг шаардаж байна. 1983 оноос эхлэн Японы цэрэг зэвсгийн хүчин чадлыг нэмэгдүүлэх таван жилийн төлөвлөгөө зохиожээ.⁹

Одоо Японы «өөрийгөө батлан хамгаалах хүч» гэгч нь 260 мянган цэрэгтэй болоод байна. Өнгөрсөн оны эцсээр АНУ-ын батлан хамгаалах яамны сайд Каспар Уайнбергер, Японы үндэсний батлан хамгаалах газрын дарга Ито Соитиро нар хэлэлцээ хийж цөмийн зэвсэг тээж чадах сөнөөгч бөмбөгдөгч «Ф—16» нисэх онгоцыг Японы агаарын цэргийн Мисава баазад байрлуулахаар хэлэлцэн тохирчээ.

⁶ Ю. Цэдэнбад. Монгол, Никарагуагийн ард түмний найрамдлын цуглаан дээр хэлсэн үг.—«Үнэн» 1983. 3.24.

⁷ БНМАУ-ын засгийн газрын мэдэгдэл.—«Үнэн» 1983. 1. 17.

⁹ «Правда» 8. 1. 1983.

Накасонэ 1983 оны 1-р сард Вашингтонд Рейгантай, Токиод АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Шульцтай хэлэлцээ хийхдээ Япон Номхон далай дахь америкийн 7-р флотын цэрэг дайны зорилгын заримыг өөртөө авч 1000 милийн горьтогт цагдах үүрэгтэй болсноо дахин нотлоод, Японы «өөрийгөө хамгаалах хүч» нь энэ ёсоор Гуам-Токио-Тайваний хоолойн гурвалжин зайд хяналтаа тогтооно гэж ийнхүү зааг гаргасан нь Японы хурдан цэрэгжин зэвсэглэж байгаад дургүйцсэн АСЕАН-ы орнуудыг тайтгаруулах гэсэн хэрэг мөн боловч, үнэн хэрэг дээрээ Японы цагдах хүрээ нь үүгээр ч хязгаарлагдахгүй, Зүүн Өмнөд Азийн орнуудад ч нэг адил хор хөнөөлтэй болно.

Японы ерөнхий сайд Накасонэ 1983 оны эхээр Вашингтон орохын өмнөхөн Өмнөд Солонгост 1-р сарын 11-12-нд яаравчлан доншуулал хийсэн нь Японы засгийн газрын тэргүүн дайны дараа анх Сеулд очсон хэрэг болж, Токио-Сеулын харилцаанд «эргэлт» гаргаж дээрх гурвалжин холбоо тогтоох ба Алс Дорнодод цэрэг зэвсгийн бодлогыг эрчимжүүлэхэд чиглэжээ.

Сая Токиогоос Сеулд олгох зээлийн хэлэлцээ дуусч, эхлээд 10 сая доллар байснаа саагдсаар 4 саяын хөнгөлттэй зээллэг олгосон нь Чон Ду Хваны цэрэг дайны нөөцийг зузаатгаж, Өмнөд Солонгос дахь америкийн цэргийн зардлыг Япон хуваалцсан хэрэг мөн бөгөөд Вашингтоны оролцоогүй даралт шахалтгүйгээр чингэсэн гэж хэрхэвч үзэж болохгүй. Өмнөд Солонгосын цэргийн зардал нь үндэсний төсвийн 30 хувийг эзлэж байна. Өмнөд Солонгосын хагас сая цэрэг нь цөмийн зэвсэг тээж чадах «Ф—16» сөнөөгч онгоц болон пуужингуудаар зэвсэглэсэн байна.

АНУ Азид цэргийн бааз 90 орчимтойгоос Японд 32, Өмнөд Солонгост 40 нь бий.¹⁰ Америкийн цэрэг Японд 50 мянга, Өмнөд Солонгост 40 мянга байна.

Америкийн империалистууд 1983 оны 2-р сараас 4-р сарын дунд хүртэл Өмнөд Солонгосын зэвсэгт хүчний хамт Өмнөд Солонгосын нутаг дэвсгэр дээр хийсэн «Тим спирит—83» цэргийн сургуульд америкийн 70 мянга, Сеулын дэглэмийн 118 мянган цэрэг оролцжээ. Энэхүү маневрт АНУ-ын 7-р флотын агаарын онгоц тээгч болон бусад хөлөг онгоц, Гуам, Окинава арал, Филиппин, АНУ-аас нисэн ирсэн «В—52» хүнд бөмбөгдөгч онгоцууд оролцож байлдааны бэлтгэлээ сорьж үзжээ.¹¹

БНАСАУ-ын Төв цахилгаан агентлаг үүнийг эрс тэс эсэргүүцэхдээ «Тим спирит—83» маневр бол БНАСАУ-ын эсрэг америкийн империалистуудын хийсэн адал балмад өдөөн хатгалга мөн бөгөөд бүх солонгосын ард түмнийг тэсвэрлэшгүй дайрч давшилж, Ази болон дэлхий дахины энх тайванд ноцтой заналхийлсэн хэрэг мөн гэжээ.¹² Мөн энэ цэргийн сургуулийг зэмлэн буруушааж «Жэньминь жибао» сонин бичихдээ, Чон Ду Хваны балмад бүлэг, АНУ-тай үгсэн сүлбэлдэж, Солонгосын энх тайвнаар нэгдэх хэрэгт саад хийж, ийнхүү зэвсэг хангинуулж байгаагаар Солонгосын хойгт түгшүүртэй байдлыг дэвэргэж, Зүүн Хойд Азийн энх тайван, аюулгүй байдалд үлэмж хор хөнөөл учруулж байна гэж тэмдэглэв.¹³

Нөхөр Ю. Цэдэнбал Японыг цэрэгжүүлэн зэвсэглүүлж байгааг хөндөж МАХН-ын Төв Хорооны 5-р бүгд хурал дээр хэлэхдээ «Японыг АНУ-ын цэрэг-улс төрийн стратегийн хүрээнд татан оруулж байгаа нь

¹⁰ «Правда» 24. 4. 1983.

¹¹ За рубежом. 1983, № 7.

¹² Мөн тэнд.

¹³ Мөн тэнд.

Алс Дорнодод улс түмний сэтгэлийг улам түгшүүлж байна. Америк-Японы «аюулгүй байдлын гэрээ» гэгчийн хор хөнөөл бодит байдалд улам тодорч, түүний уршгаар Японд милитаризм сэргэж байна. Энэ нь Азийн улс түмний, түүний дотор Японы ард түмний үндсэн эрх ашигт илт харшилж байгаа юм»¹⁴ гэжээ.

Америкийн империализм БНХАУ-ын газар дэвсгэрийн салшгүй хэсэг-Тайванийг энх тайвнаар эх газартайгаа нэгдэхэд элдэв саад үзүүлэн, түүнийг орчин үеийн зэвсгээр шургуу зэвсэглэх чиг шугамаа ер орхихгүй байна. Урьд хожид АНУ Тайваньд үлэмж зэвсэг нийлүүлсний дээр сүүлийн хэдэн сард тийрэлтэт сөнөөгч онгоц 66-г худалдах болсноос эхний хэсгийг нь 1982 оны 12-р сард явуулж, үлдэх 14-ийг ойрын хугацаанд залгуулах болов гэж АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга нарын газар 1983 оны 2-р сарын 10-нд мэдэгдэв. АНУ, Тайваньтай хамтран «Ф—105Е» онгоц хамтран үйлдвэрлэх явдлыг өргөтгөхийн зэрэгцээ, Тайваний хуучирсан онгоцуудыг шинээр солих бодлоготой байна.¹⁵

БНМАУ Тайванийг БНХАУ-ын муж гэж үзэж түүнийг эх нутагтайгаа энх тайвнаар нэгдэхийг дэмжихийн хамт тэрхүү арлыг америкийн империализмээс Ази дахь жанжлах бодлогынхоо дагуу «Азид шинэ колоничлолын хуягласан бэхлэлт болгоход чиглэж байгааг» «Үнэн» сонин 1983 оны 4-р сарын 17-ны дугаарт дахин эрс буруушаажээ.¹⁶

Ойрхи Дорнод, Персийн булан, Энэтхэгийн далайн байдал улам хурцдаж байна.

Сүүлийн үеийн мэдээгээр үзвэл, сионист цэргүүд Ливаны өмнөдөд орогносоор түүнийг арабын орнууд, юуны өмнө Сирийн эсрэг түрэмгийлэл өргөжүүлэн явуулах түшиц газар болгон хувиргаж байна. Бекаа хөндий, Триполи хотын орчим, Алей тойрог зэрэг газарт израилийн түрэмгийлэгчид дураар аашлаж энгийн номхон иргэдийн эсрэг аллага таллага явуулж, Ливанд энх тайванг сахих араб дундын хүчнийг дайрч өдөөч хатгаж, Сирийн цэргийн байрласан газрыг буудаж Сири улсын хил дээр зэвсэг ханигнуулан сүрдүүлж байх боллоо.¹⁷

МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал Арабын Социалист Сэргэн Мандалтын Намын Ерөнхий нарийн бичгийн дарга, Арабын Бүгд Найрамдах Сири Улсын ерөнхийлөгч Хафез Асадад 1983 оны 4-р сарын дундуур явуулсан цахилгаан утсандаа Израилийн дайнчид Вашингтоны идэвхтэй оролцоотойгоор АБНСУ-ын эсрэг цэрэг дайны бэлтгэлээ улам илэрхий хийж байгааг эрс буруушав.¹⁸

Вашингтон Израилийг Сирийн эсрэг тухирч байхын далимд Ливанд оруулсан цэргээ гаргахгүй, тэнд улам батжуулж авахыг чармайж байна. Энэ тухай хамаг учрыг уудлан А. А. Громыко Москвад болсон хэвлэлийн бага хурал дээр хэлэхдээ, «Ийнхүү Вашингтоныхон Ливанд цэргээ оруулж батжаад байна. Тэд америкчууд цэргийнхээ ангиудтай хамт Ливанаас гарч явна, гэхдээ тэндээс Израиль болон гадаадын бусад бүх цэрэг гарах ёстой гэж ярьж байна. Израиль болохоор бид гарах бодолгүй байна гэж ярьж байна. Ингэхэд Вашингтоныхон Израиль гарахгүй гэж байгаа болохоор бид ч мөн гарахгүй гэж ярьж байна»¹⁹ гэжээ.

Ойрхи Дорнодын талаархи америк-израилийн бодлогыг дэлхийн улс түмэн зүй ёсоор эсэргүүцэж байна. 1983 оны 2-р сарын 7-ны Синь-

¹⁴ Ю. Цэдэнбал, МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал дээр хэлсэн үг. — «Үнэн», 1982. 12. 8.

¹⁵ «Правда» 11. 2. 1983

¹⁶ «Үнэн» 1983. 4. 17.

¹⁷ «Правда» 1983. 4. 17.

¹⁹ А. А. Громыко. Хэвлэлийн бага хурал дээр хэлсэн үг. — «Үнэн» 1983. 4. 5

²⁰ Синьхуа-гийн мэдээ. «Правда» 8, 2. 1983.

хуа агентлагийн мэдээг иш татвал, Ойрхи Дорнодод АНУ-ын хувийн эрх ашиг хөөцөлдсөн байр суурь ба Израилийг түшиж, тулж байгаа нь Тель-Авивын эзлэн түрэмгийлэх бодлогыг өөгшүүлж байна гэж хятадын тал үзэж байна гэж цохон тэмдэглэжээ.²⁰

Энэ бүс нутгийн амгалан тайван байдалд муу нөлөөлж буй нэг явдал бол одоо хүртэл үргэлжилсээр буй иран-иракийн дайн мөн. 1983 оны эхний байдлаар Иран нь Иракийн нутаас 300 шоо дөрвөлжин км газар нутгийг эзлээд байгаа ба хоёр тал тулалдааны явцад амьд хүч, зэр зэвсэг, байлдааны техникийн их гарз хохирол үзсээр ажээ.

Байлдагч хоёр тал Иран Иракийн алинд ч ашиг тус өчүүхэн ч үгүй, харин империализм, сионизм ба бусад харгис хүчнээс энэ бүс нутагт булаан эзлэх бодлогоо биелүүлэх, ер нь үндэсний эрх чөлөөний ба эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг сулруулахад нь дөхөм үзүүлж буй энэхүү дайныг даруй зогсоохыг юуны өмнө Арабын дорно дахин өөрийн нь аюулгүй байдал шаардаж байна.

Империалист болон элдэв харгис хүчин ардчилсан Афганистаныг тойруулан байдлыг их түгшүүртэй болгох бодлогоо орхихгүй, улам идэвхжүүлсээр ирлээ.

АНУ Дундад Дорнод дахь өөрийн холбоотон Пакистан, Азийн бас бус харгис хүчний хамт БНААфГУ-ын эсрэг зарлаагүй дайныг хүчтэй болгож байгаагийн нэг шинэ илрэл нь 1983 он гарсаар АНУ-ын ерөнхийлөгч Рейган Афганы хувьсгалын эсэргүүчүүдийг хүлээн авч тэдэнд буу зэвсэг болон өөр бусад тусламж улам их үзүүлэхээр амласан явдал мөн.²¹

Америкийн империализм ба бусад харгис хүчний тусламжгүй ахул, Афганы ардчилсан төрд хонзогногчид эсэргүүчүүд ингэтлээ даврахгүй байсан билээ. АНУ тэдэнд зориулан 218 сая доллар, НАТО-гийн холбоотон Баруун Герман, Англи нь тус тус 60 сая, 18 сая доллар зарцуулж, Пакистан дахь 80 лагерьт 100 мянган дээрэмчдийг орогнуулан хорлон сүйтгэх ажилд сургаж БНААфГУ-ын эсрэг шургалуулж байна.

Гэвч дайсан юу хийвч, 1978 оны дөрөвдүгээр сарын хувьсгал Афганистанд эргэлтгүй ялсан нь тодорхой юм.

1983 оны 1-р сард МОНЦАМЭ Афганистаны талаар мэдэгдэл нийтлэж, «Афганистаны эргэн тойронд бий болсон байдлыг улс төрийн аргаар зохицуулахыг ЗХУ ТАСС-ын мэдэгдлээрээ дахин уриалсныг Монголын олон нийт бүрэн дэмжиж байна»²² гээд, энэ асуудлыг БНААфГУ-ын засгийн газрын 1980 оны тавдугаар сар, 1981 оны наймдугаар сарын оновчтой саналыг баримтлан шийдвэрлэхийн хойшлуулшгүйг цохон тэмдэглэв.

АНУ Энэтхэгийн далайд юуны өмнө Диего-Гарсия арал дээр цөмийн зэвсэг хадгалах агуулахуудыг барьж цэрэг дайны бэлтгэл шургуу хийж байгааг Энэтхэгийн далайн эргийн улсууд, ЗХУ ба социалист бусад орнууд буруушааж энэхүү далайг энх тайвны бүс болгон хувиргахын төлөө тууштай тэмцэл явуулж байна.

БНМАУ Энэтхэгийн далайн талаар олон улсын бага хурлыг зарлан хуралдуулах тухай НҮБ-ийн шийдвэрийг дэмжиж байна. Сүүлийн үеийн мэдээгээр үзвэл, юуны өмнө АНУ Энэтхэгийн далайг энх тайвны бүс болгон хувиргах арга хэмжээг хэлэлцэх олон улсын бага хурлыг хуралдуулах явдлыг 1981 оноос тасалдуулсаар ирсэн ба 1983 онд ч бас таслав.

Үүгээр үл барам АНУ Персийн булан, Энэтхэгийн далайн районы байдлыг улам хурцатгахаар энэ 1983 оны 1-р сарын 1-нээс Сентком бу-

²¹ «Правда» 11. 2. 1983.

²² «Үнэн» 1983 1. 6.

юу Төвийн командлал хэмээх цэргийн бас нэг байгууллага байгуулж, «түргэн давших хүч» (1980 оноос бий болсон) Диего-Гарсия арал, Оман, Сомали, Кени ба бас бус орны нутаг дэвсгэр дээрх баазууд, Персийн буланг цагдан манадаг нисэх онгоц тээгч хөлөг онгоцууд зэргийг захируулжээ.²³

Америкийн империалистууд Ази дахинд ноёрхол тогтоох хэнээт бодлогоо явуулахдаа Номхон далайг ч амар дөлгөөн байлгахгүй, тэнд цэрэг дайны бэлтгэл шургуу хийж байна. Энэ нь Филиппин, Австралийн нутаг дэвсгэр, Микронезийн арлууд дээр ч америкийн цэргийн баазуудад цөмийн шинэ шинэ зэвсэг байрлуулахаар зэхэж байгаагаас тодорхой ажээ.

Дээр дурьдсанаас үзвэл, Азийн өргөн уудам нутаг дэвсгэр, далай тэнгисээр тархан байрласан америкийн цэргийн баазууд, тус тивийн харгис дэглэмт улсуудын зүгээс ЗХУ, БНМАУ, социалист бусад орнуудад цөмийн зэвсгээр заналхийлэх явдал өсөн нэмэгдэж байна.

АНУ-ын ерөнхийлөгч Рейганы дэвшүүлсэн «тэглэх хувилбар» түүнээс үл ялгагдах «завсарын хувилбар» гэгчийн бас нэг зорилго нь Азийн нутаг дэвсгэрт нь буй зөвлөлтийн дунд зайны пуужинг устгуулахад орших бөгөөд тус тивийн улс түмэнд аюултай юм.

Ю. В. Андропов Баруун Германы «Шпигель» сэтгүүлд өгсөн хариундаа зэвсэглэлийн асуудлын чухам энэ талыг хөндөн өгүүлснээс нь иш татвал, АНУ-ын засаг захиргаа бидэнд дангаар зөвхөн Өрнөдөд-Европт төдийгүй, мөн Дорнодод-Азид ч зэвсгээ хураахыг шаардан ЗХУ-ын азийн хэсэгт манай дунд зайны пуужинг байрлуулахгүй гэж болзол тавьж байна гэжээ.²⁵

Ази дахь зөвлөлтийн пуужингууд нь Европын орнуудад аюулгүй, харин ЗХУ-ын өөрийн нь аюулгүй байдалд хэрэгтэй юм. Үүнийг А. А. Громыко тодорхой баримтаар нотлон хэлэхдээ «Тэдгээр нь Зөвлөлт Холбоот Улсад өөрийгөө аюулгүй байлгахад хэрэгтэй, Америкийн цэргийн баазууд Зөвлөлт Холбоот Улсыг ямаршуу байдлаар бүсэлсэн нь нэн тодорхой шүү дээ. Япон улс, тус улсын эргэн тойрны усыг цөмийн зэвсэг, зохих зөөгч хэрэгслээр дүүргэсэн юм. Окинава арал цөмийн зэвсгийн асар том бааз юм. Өмнөд Солонгос мөн асар том бааз, нарийн хэлбэл, цөмийн зэвсгийн цогцолбор бааз юм. Энэтхэгийн далайд, ялангуяа Диего Гарси баазад Зөвлөлт Холбоот Улсын нутагт хүрэх цөмийн зэвсэг байрлуулжээ. Персийн булан, түүнтэй залгаа улсыг цөмийн зэвсгээр дүүргэсэн юм. Тэгэхдээ дунд зайны тусгалтай зэвсэг гэдгийг анхаарахыг би та нарт хүсэж байна. Тэдгээр бүх зэвсэг зөвлөлтийн нутагт хүрэх юм. Түүгээр ч барахгүй, миний одоо хэлэх гэж байгаа зүйлийг мэдэхгүй хүн байгаа бол энэ зэвсэг Сибирийн бүх нутаг, Зөвлөлт Холбоот Улсын нийт Азийн хэсэг, тэр ч байтугай хамгийн хойд нутаг-Таймырын хойгт хүрнэ гэдгийг мэдвэл түүнд нэн сонин байх болно»²⁶ гэжээ.

Социалист Монгол улс Зүүн Өмнөд Азид тогтвортой байдлыг батжуулж, империалист харгис хүчний өдөөн хатгалгыг таслах аливаа алхмыг дэмжсээр ирлээ. 1983 оны 2-р сард Вьентьянд БНСВУ, БНАЛАУ, БНХАУ-ын дээд хэмжээний зөвлөлгөөн анх болж тус гурван орон болон АСЕАН-ы хооронд сайн хөршийн харилцааг тогтоон бэхжүүлэх, хамтын хүчээр Зүүн Өмнөд Азийн энх тайван, аюулгүй байдлыг хангах талаар дахин шинэ санаачилга дэвшүүлснийг БНМАУ-ын засгийн газар 1983 оны 2-р сарын 28-ны мэдэгдэлдээ өндрөөр үнэлсэн билээ.

²³ «Правда» 11. 1. 1983.

²⁴ «Правда» 25. 4. 1983.

²⁵ Ю. В. Андропов, «Шпигель» (ХБНГУ) сэтгүүлд өгсөн хариу. — «Правда» 25. 4. 1983.

²⁶ ЗХУ-ын Гадаад явдлын Яамны сайд А. А. Громыко хэвлэлийн бага хурал дээр хэлсэн үг, — «Үнэн». 1983. 4. 5.

Энэхүү мэдэгдэлд өгүүлсэн нь: «Энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр АСЕАН-ы онуудтай сайн хөршийн харилцаатай байх, маргаантай аливаа асуудлыг эв зүйгээр шийдэх, эрх тэгш байх болон бүс нутгийн бүх улс орны эрх ашгийг харгалзсан үндсэн дээр яриа хэлцээ хийхэд Вьетнам, Лаос, Кампучи бэлэн байгаагаа Вьентьяны дээд хэмжээний зөвлөлгөөнд илэрхийлэв. Үүнтэй холбогдуулан бусдын дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зарчмыг сахих, нэг улсын нутаг дэвсгэрийг нөгөө улсын эсрэг хорлон сүйтгэх ажиллагаанд ашиглахыг зогсоох нь чухал болохыг тэмдэглэв»²⁷.

Зүүн Өмнөд Азийг энх тайван, тогтвортой байдлын бүс болгон хувиргах нь энэ бүс нутаг, нийт Азийн улс түмний чин эрмэлзлэл мөн тул энэ санааг хэрэгжүүлэх нь чухал юм.

Гэтэл империалист харгис хүчнүүд АСЕАН-ы орнуудыг Энэтхэг-хятадын хойгийн гурван орны эсрэг тухирч тэдгээрийн хооронд харилцан ойлголцож итгэлцэх явдалд элдэв саад учруулан энэ бүсийн байдлыг тогтворжуулах нь байтугай, улам хурцатгаж өөрсдийн жанжлах бодлогоо хүчтэй болгосоор байна.

1983 оны 3-р сард Дели хотноо эвсэлд үл нэгдэгч орнуудын VII бага хурал болж өнгөрсөн нь Ази болон дэлхий дахины олон улсын амьдралд чухал үйл явдал боллоо.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний гишүүн 97 орон оролцсон олон улсын энэ бага хурал колоничлол, шинэ колоничлол империализмын эсрэг цаашид явуулах тэмцэлд тэрхүү улсуудын эгнээг улам нягтруулж, орчин үеийн олон улсын тулгамдсан асуудлуудаар нэг нэгдмэл байр суурийг тодорхойлжээ.

Делийн улс төрийн тунхаглалд дурьдахдаа «Манай үеийн гол асуудал бол энх тайван, энх тайвнаар зэрэгцэн орших, зэвсэглэл хураах, хөгжин дэвших явдал мөн. Энх тайван бол шударга ёс, тэгш эрхийн үндсэн дээр тулгуурлах ёстой. Учир нь колоничлол ба империализмын тогтоосон тэвчимгүй тэгш бус, дарлан мөлжих явдал дэлхий дахинд хурцадмал байдал, зөрчил тэмцэл, хүч хэрэглэхийн гол эх сурвалж болж байна» гэж тэмдэглэжээ. Эвсэлд үл нэгдэгч улсууд цөмийн дайнд халтиран орохыг нэн даруй зогсоож, цөмийн зэвсгийг ямар ч нөхцөлд гэсэн хэрэглэхийг хориглох олон улсын Конвенц байгуулахыг цөмийн зэвсэгт гүрнүүдээс шаардлаа. Одоогийн олон улсын эдийн засгийн системд буй тэгш бус, шударга бус явдлыг шүүрдэн хаяж, олон улсын эдийн засгийн шинэ дэг журам тогтоох нь эвсэлд үл нэгдэгч улсуудын улс төр, нийгмийн хувьд чөлөөлөгдөх тэмцлийн салшгүй хэсэг гэж үзжээ.

Манай гариг дээр энд тэнд үлдсэн колоничлол, арьс өнгөөр ялгаварлах явдлыг эцэс болгон устгахыг Делийн зөвлөлгөөн уриалав.

Мөн 1983 оны 4-р сард Улаанбаатарт болсон Ази, Номхон далайн энх тайван, аюулгүй байдлын төлөө бүсийн бага хурал, түүний дүнгээс үзвэл, энэ асуудлаар БНМАУ-ын дэвшүүлсэн тодорхой саналыг эрс дэмжин, Ази тивийн улс төрийн уур амьсгалыг эрүүлжүүлэхэд дурьдсан бүсийн олон нийт зориг төгс байгааг илтгэн харууллаа.

Ази ба дэлхий дахины энх тайван, аюулгүй байдалд нааштай нөлөө үзүүлэх нэн чухал хүчин зүйл бол хоёр их гүрэн ЗХУ ба БНХАУ-ын хооронд сайн хөршийн харилцааг сэргээн тогтооход оршиж байна. Мөн түүнчлэн, нэг талаас, БНХАУ, нөгөө талаас БНМАУ, БНСВУ, БНАЛАУ, БНКАУ-ын хооронд харилцан ойлголцсон сайн хөршийн харилцааг сэргээвэл дээрх чигт үйлчлэхсэн билээ.

²⁷ БНСВУ, БНАЛАУ, БНКАУ-ын Вьентьяны хамтарсан албан мэдэгдлийн тухай БНМАУ-ын засгийн газрын мэдэгдэл. — «Үнэн» 1983. 3. 1.

МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга Ю. Цэдэнбал МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал дээр 1982 оны 12-р сард хэлсэн үгэндээ монгол-хятадын харилцааны талаар дурьдахдаа «Азийн нэлээд районы өнөөгийн байдалд сэтгэл түгшиж байгаа БНМАУ ХКН-ын XII их хурлаас хойш хятадын эрх баригчдын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг анхааралтай ажиглан харж байна.

Монгол-хятадын харилцааг социализм, энх тайвны эрх ашигт нийцсэн зарчмын үндсэн дээр хэвийн болгож болно гэсэн тууштай байр суурийг манай орон баримталсаар байгааг энэ индэр дээрээс дахин батлан хэлэхийг хүсэж байна»²⁸ гэжээ.

Манай улс өмнөх хөрш БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгохын төлөө өөрөөс шалтгаалах бүхнийг хийж байна. Гэтэл хятадын тал, сүүлийн үеийн мэдээ баримтаас үзвэл, энэ чигт сайн санааны тодорхой алхам хийхгүй байгаа нь харамсалтай ажээ.

БНМАУ үүний урьд Азийн аюулгүй байдлыг эрхэмлэн, Ази, Номхон далайн орнуудын хооронд харилцан үл довтолох, хүч үл хэрэглэх тухай конвенц боловсруулж байгуулах талаар дэвшүүлсэн саналыг Энэтхэг мэт Азийн олон орон талархсан байтал, БНХАУ үгүйсгэсээр байна. Мөн ЗХУ, БНХАУ-ын харилцааг сайжруулах зорилготой явагдаж буй зөвлөлт-хятадын хэлэлцээн дээр хятадын тал тус хоёр орны талаархи асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх явдлыг гуравдахь оронтой холбож, тухайлбал, манай БНМАУ-д түр байрлаж буй зөвлөлтийн цэргийн ангийг татан гаргахыг шаардаж, ер нь БНМАУ, БНСВУ, БНКАУ, Афганистаны дотоод асуудалтай хамааруулж уул хэлэлцээг сунжруулж байгаа нь зүйд үл нийцнэ. Монголын тухайд ахул, БНМАУ-ын хэргийг монголын ард түмний ар хударгаар Москва буюу Бээжинд шийдвэрлэх улигт байр суурийг хятадын тал баримталсаар байна. Үүнийг Монголын олон нийт хэзээ ч зөвшөөрөхгүй нь мэдээж хэрэг. ЗХУ нь зөвлөлт, хятадын хэлэлцээн дээр тус хоёр орны харилцааг хэлэлцэхээс биш, ямар нэг гуравдахь орныг хөндсөн асуудал хэлэлцэхгүй гэсэн байр суурь баримталж байгаа нь ойлгомжтой бөгөөд зүй ёсны хэрэг мөн. Энэ тухай «Үнэн» сонин 1983 оны 4-р сарын 17-нд нийтэлсэн «Төрийн бүрэн эрхийг хүндэтгэх явдал сайн хөршийн харилцааны салшгүй хэсэг мөн» өгүүлэлд бичихдээ «Бээжингийнхэн бас зөвлөлт-хятадын зөвлөлдөх уулзалт дээр БНМАУ, БНСВУ, БНКАУ, Афганистан зэрэг гуравдахь орны үндэсний эрх ашигт хамаарах асуудлыг хэлэлцэхээс татгалзлаа гэж Зөвлөлт Холбоот Улсыг зэмлэх гэж санаархаж байна. Зөвлөлтийн энэ байр суурь бол харин ч сайшаавал зохих зүйл гэдгийг хэлэх хэрэгтэй юм. Үүнээс өөр байх ёс ч үгүй юм. Чухамхүү Зөвлөлт Холбоот Улс л Монгол орны тусгаар тогтнон хөгжихтэй холбогдсон асуудлыг Бээжинд ч биш, Москвад ч биш, харин Улаанбаатарт монголын ард түмэн өөрсдөө шийдвэрлэх ёстой гэдгийг нэг бус удаа мэдэгдсэн юм шүү дээ» гэж тэмдэглэжээ.

Ази дахины байдал өнөөдөр түгшүүртэй байгаагийн гол шалтгаан нь америкийн империализм ба аливаа бусад харгис хүчнээс тус тивд явуулж буй өдөөн хатгах, эзлэн түрэмгийлэх бодлогонд оршино.

Бүгд Найрамдах Монгол Ард Улс Азийн өнөөгийн улс төрийн үйл явдалд бодит дүгнэлт хийж, тус тивд энх амгалан, тогтвортой байдлыг ханган бэхжүүлэхийн төлөө тэмцлээ эрчимжүүлэх болно.

²⁸ Ю. Цэдэнбал, МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал дээр хэлсэн үг.— «Үнэн», 1983. 12. 8.

²⁹ «Үнэн», 1983. 4. 17.

БОРЬБА ЗА УКРЕПЛЕНИЕ БЕЗОПАСНОСТИ НА АЗИАТСКОМ КОНТИНЕНТЕ

(Резюме)

Вследствие активизации глобальной агрессивной политики американского империализма и его союзников обстановка в Азии и во всем мире остается по-прежнему напряженной.

Политика американского империализма, рассчитанная на дестабилизацию обстановки на Дальнем Востоке, на Ближнем и Среднем Востоке, в Юго-Восточной Азии, в бассейнах Индийского и Тихого океанов, ускоренная милитаризация Японии, Южной Кореи, Пакистана и ряда других азиатских стран, где вершат делами реакционные режимы, расширение и модернизация существующих военных баз, где уже размещено или планируется разместить ядерное оружие - все это свидетельствует о сложной взрывоопасной ситуации на континенте.

В противоположность этому авантюристическому курсу империализма и реакции, страны социалистического содружества выступили с рядом новых миролюбивых инициатив, направленных на предотвращение опасности ядерной войны, что явилось весомым вкладом в благородное дело сохранения всеобщего мира.

Монгольская Народная Республика совместно с другими социалистическими странами, со всеми миролюбивыми силами мира последовательно борется за мир и международную безопасность, при этом, как азиатская социалистическая страна, прежде всего уделяет особое внимание укреплению взаимопонимания и доверия между государствами на континенте.

Этой задаче подчинено предложение МНР созвать конференцию государств Азии и Тихого океана с целью выработать и подписать конвенцию о взаимном ненападении и неприменении силы между государствами, а также известная инициатива ДРА о мирном урегулировании положения вокруг Афганистана, призыв Вьетнамского совещания высших руководителей СРВ, Лаоса и Кампучии к развитию добрососедских отношений со странами АСЕАН, к укреплению мира и безопасности в Юго-Восточной Азии.

Большой вклад в дело укрепления международного доверия вносят общественные организации, выступающие за мир и безопасность народов. Примером тому может служить состоявшаяся в апреле 1983 г. в Улан-Баторе региональная конференция «За мир и безопасность в Азии и районе Тихого океана» с участием представителей общественных организаций многих стран этого региона.

В заключение автор отмечает необходимость дальнейшей активизации совместных усилий стран социализма и всех прогрессивных сил в борьбе за мир, разоружение, безопасность на континенте, против угрозы ядерной войны.